



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас: 31-03-92, Факс: (976-11) 31-14-71,
<http://www.mongolbank.mn>

2013.08.29 № A-1/1122

танай _____-ны № _____-т


УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ГАРАМГАЙБААТАР ТАНАА

Танай 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 11/5182 дугаар албан бичгийн дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, тус зөвлөлөөс гаргасан шийдвэрийн талаарх мэдээлэл, холбогдох тайланг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авч танилцана уу.

Хавсралт 3... хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГН



Н.ЗОЛЖАРГАЛ

Баттэс ай ханга
Золжаргал
2013.08.29
3161

A5-2013.doc

Монголбанкны 2013 оны 08 дугаар сарын
29-ны өдрийн 9-1/11132 албан бичгийн
хавсралт

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ(СТБЗ)¹-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаан

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хууль болон Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэл батлагдсанаас хойшхи хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ) нь 2012 оны 12 дугаар сарын 5, 2013 оны 2 дугаар сарын 19-ний өдөр бүрэн бүрэлдэхүүнээр хуралдсан бөгөөд эдгээр хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн болно:

- *Засгийн газрын үнэт цаасны арилжааг идэвхжүүлэхэд шаардлагатай зарим арга хэмжээний тухай*

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга “Засгийн газрын үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх зарим арга хэмжээний тухай” хамтарсан тушаалыг баталж, мөрдлөг болгон ажиллаж байна. Эдгээр шийдвэрийг гаргаж, холбогдох журмыг батлан мөрдсөнөөр Засгийн газрын үнэт цаасыг зөвхөн төсвийн цаг үеийн, богино хугацааны орлого, зарлагын зөрүүг санхүүжүүлэх төдийгүй бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасыг мөнгөний бодлогын хэрэгсэл хэлбэрээр ашиглах, төсөв, мөнгөний бодлогын уялдааг сайжруулах, үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн жишиг өгөөжийн муруй бүрэлдэх, бусад санхүүгийн хэрэгслүүдийг үнэлэх, зах зээлд нэвтрүүлэх боломж бүрдэж, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой алхам болов. Түүнчлэн, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 25-ны 217/А-161 дугаар хамтарсан тушаалаар Засгийн газрын үнэт цаас гаргах, арилжаалах журам, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 5 дугаар сарын 21-ний 111/А-105/131 дугаар хамтарсан тушаалаар Засгийн газрын үнэт цаасыг хоёрдогч зах зээлд арилжих журмыг баталсан. (Холбогдох хамтарсан тушаал, журмыг хавсаргав.)

Дээр дурдсан журмын дагуу Засгийн газрын үнэт цаасны анхдагч захын арилжаа 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр, хоёрдогч захын арилжаа 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдөр эхэлсэн бөгөөд 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 1 их наяд 41 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаас гараад байна. Мөн хугацаанд Засгийн газрын үнэт цаасны жигнэсэн дундаж хүү буурсаар ирлээ.

¹ Төвбанкны тухай хуулийн 27.2-т Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл ажиллана, Зөвлөлийн дүрмийг гишүүд хамтран батлана, Зөвлөл нь ажлын албатай байна гэж тус тус заасан байдаг.

▪ *СТБЗ-ийн ажиллах дүрэмд өөрчлөлт оруулах тухай*

Санхүүгийн салбарыг хөгжүүлэх, түүний тогтвортой байдлыг хангах чиглэлд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг илүү үр дүнтэй болгоход түүний гүйцэтгэх үүргийг дараах чиглэлд өргөжүүлэх шаардлагатай юм. Үүнд:

- Макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын тогтвортой байдлын бодлогын харилцан уялдааг хангах;
- Макро зохистой бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх;
- Санхүүгийн салбарын эрсдэлийн үнэлгээг хийх, түүнээс сэргийлэх арга хэмжээ авах;
- Санхүүгийн институцийн реформыг Засгийн газрын нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулан хийх;
- Олон нийтийн санхүүгийн байгууллагуудад итгэх итгэлийг бэхжүүлэх чиглэлд өргөжүүлэх.

СТБЗ-ийн үйл ажиллагааг дээрх чиглэлээр өргөжүүлэх хүрээнд Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд ч холбогдох заалтууд тусгалаа олсон. Тухайлбал, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлийг баталсан УИХ-ын тогтоолын 2 дахь хэсэгт “СТБЗ-ийн үйл ажиллагааг төлөвшүүлэх, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор макро зохистой бодлогыг харилцан уялдаатай хэрэгжүүлэн, санхүүгийн салбарын байдлыг улирал бүр нийтэд мэдээлэх арга хэмжээг авч ажиллах” тухай заалт орсон.

Энэхүү заалтыг хэрэгжүүлэх болон СТБЗ-ийн төрийн бодлогын шийдвэр гаргалтанд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх хүрээнд СТБЗ-ийн Ажлын албаны үйл ажиллагааг санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, санхүүгийн салбарын дархлааг сайжруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээний санал боловсруулах, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайланг тогтмол гаргах, СТБЗ-ийн гишүүд болон олон нийтийг мэдээллээр хангах чиглэлд өргөжүүлэх, чадамжийг нэмэгдүүлэх шаардлага үүссэн.

СТБЗ нь 2010 онд байгуулагдсанаасаа хойш СТБЗ-ийн ажиллах дүрэм дагуу ажлын алба нь албан ёсны 1 орон тоотойгоор (СТБЗ-ийн ажлын албаны дарга бөгөөд нарийн бичгийн дарга) ажиллаж ирсэн бөгөөд тус хуралдаанаар СТБЗ-ийн ажиллах дүрэмд холбогдох өөрчлөлтийг оруулж, Ажлын албаны орон тоог 4-өөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. (СТБЗ-ийн ажиллах дүрмийг хавсаргав.)

▪ *Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн агуулгын эхний хувилбарыг батлах тухай*

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн агуулгыг баталж, анхны дугаарыг бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, цаашид хагас жил тутам гаргах ажлыг зохион байгуулах үүргийг СТБЗ-ийн Ажлын албанд өгсөн. Энэ дагуу СТБЗ-ийн Ажлын алба нь Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан – 2012 буюу анхны дугаарыг нэгтгэн боловсруулж, нийтийн хүртээл болгов. Одоогоор СТБЗ-ийн Ажлын алба нь Санхүүгийн тогтвортой байдлын 2013 оны эхний хагас жилийн тайланг боловсруулж байна. (Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан – 2012-ыг хавсаргав.)

II. Дэлхийн банкны зөвлөх ажилласан тухай

Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй MSTAR төслийн хүрээнд СТБЗ-ийн Ажлын албан дээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах чиглэлээр гадаад зөвлөх 2013 оны 6 дугаар сарын 1-нээс 28-ны хооронд ажиллалаа. Зөвлөхийн гаргасан тайлангийн агуулгад СТБЗ-ийн үйл ажиллагааны нийтлэг хэм, хэмжээ, олон улсын туршлага, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэрэгслүүд, түүний хэрэглээ, энэхүү чиглэлээр Монгол Улсын хууль эрх зүйн орчинд өгөх санал, зөвлөмжийг хамруулсан бөгөөд СТБЗ-ийн Ажлын албаны зүгээс холбогдох төрийн байгууллагуудын төлөөлөлтэй тус сэдвээр хоёр удаа хэлэлцүүлэг зохион байгуулав.